

**СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ 2015 ОНЫ
АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ**

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Төлөвлөгөөний хэрэгжилт	Хуудасны дугаар
1	Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, энэ талаархи мэдээллийг иргэд, байгууллага чөлөөтэй авах нөхцлийг хангах	<p>1.1.Авлигын эсрэг хууль тогтоомжийг боломжит хэлбэрээр сурталчлах /мэдээллийн самбар, цахим хуудас, яриа таниулга, теле сурталчилгаа, сонсгол, нээлттэй өдөрлөг, хэлэлцүүлэг, хэвлэмэл материал г.м/</p> <p>1.2.Авлигатай тэмцэх газраас бэлтгэн хүргүүлсэн сурталчилгааны материалыг иргэд, байгууллага, албан хаагчдад түгээн ажилласан байх</p>	<p>Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон бусад холбогдох эрх зүйн актуудыг тус Хорооны цахим хуудасны “Сонгуулийн Ерөнхий Хорооны авлигын эсрэг үйл ажиллагаа”/“Авлигын эсрэг хууль тогтоомж” цэсэнд байршуулсан.</p> <p>Авлигатай тэмцэх газраас бэлтгэн ирүүлсэн сурталчилгааны зурагт хуудас болон наалтуудыг Хорооны ажлын байранд байрлуулсан болно.</p> <p>Хорооны нийт албан хаагчдыг Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн Авлигын эсрэг эрх зүйн баримт бичгийн эмхтгэл, Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг гаргагч нарт зориулсан гарын авлагаар хангаж ажилласан.</p>	40-49
2	Шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг ба нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг олон нийтэд танилцуулах, сонирхогч бүлгүүдтэй харилцан санал солилцох	<p>2.1.Боловсруулж байгаа хууль, Улсын Их Хурал, Засгийн газар, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төсөлд иргэд, олон нийт, сонирхогч бүлгийн санал, шүүмжлэлийг цахим хуудсаар хүлээн авах боломжийг бүрдүүлэх</p> <p>2.2.Боловсруулж байгаа хууль, Улсын Их Хурал, Засгийн газар, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг цахим хуудсандаа байршуулсан байх</p> <p>2.3.Дээрх асуудлаар иргэд, олон нийт, сонирхогч бүлгүүдтэй харилцан санал солилцсон байх</p>	<p>Сонгуулийн Ерөнхий Хорооноос сонгуулийн нэгдсэн хуулийн төсөлд тусгах саналуудыг боловсруулан тус Хорооны цахим хуудасны “хууль, тогтоомж”/ “Сонгуулийн нэгдсэн хуулийн төсөл” цэсэнд байршуулан иргэд, ТББ уг саналтай танилцах, санал өгөх боломжийг бүрдүүлэн, иргэд, байгууллагаас тус Хороонд гаргасан санал, зөвлөмжийг нэгтгэн холбогдох албан тушаалтанд хүргүүлэн ажиллаж байна.</p> <p>2015 оны хувьд тус Хорооноос нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон эрхийн акт гараагүй болно.</p> <p>Эдгээр журам, заавар, загвар, маягтыг цахим хуудасны “Хууль тогтоомж”/ “Сонгуулийн ерөнхий хорооны шийдвэр” цэсэнд сонгууль тус бүрээр төрөлжүүлэн байршуулж иргэд, сонгогчдод нээлттэй танилцах боломжийг бүрдүүлж ажиллаа.</p>	50-63
3	Төрийн хяналтын үйл ажиллагааны	3.1.Тухайн жилд явуулах хяналт шалгалтын ажлын төлөвлөгөө /төлөвлөгөөт/-г цахим хуудсандаа байршуулсан байх.	Архив, албан хэрэг хөтлөлт, төрийн байгууллагын ажлын зохион байгуулалтын улсын үзлэгт бэлтгэх ажлын хэсгийг тус Хорооны даргын 2015 оны 23 дугаар захирамжаар байгуулан улсын үзлэгт бэлтгэх ажлын төлөвлөгөөг баталсан. Энэхүү төлөвлөгөөнд	

	ил тод, нээлттэй байдлыг хангах	<p>3.2. Хийсэн хяналт шалгалтынхаа дүнг олон нийтэд мэдээлсэн байх /цахим хуудсаар, хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлсэн байх/</p> <p>3.3.Хяналт шалгалтын мөрөөр авсан арга хэмжээ/дүгнэлт, акт, зөвлөмж гаргах, түүний мөрөөр холбогдох арга хэмжээг авсан байдал/-ний үр дүнгийн талаар мэдээлсэн байх.</p>	тусгагдсан ажлын хүрээнд тус Хорооны албан хаагчдын ажлын зохион байгуулалт, албан хэрэг хөтлөлт, баримт бичгийн эмх цэгц болон боловсруулж буй албан бичиг, ажлын бусад баримт материал холбогдох журам, стандартад нийцэж буй эсэхэд хяналт, шалгалт тавьж ажиллав. Тус Хорооны цахим хуудсанд Архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгт бэлтгэх ажлын хэсэг байгуулах тухай тус Хорооны даргын захирамж болон улсын үзлэгт бэлтгэх ажлын төлөвлөгөө, Архивын ерөнхий газрын улсын байцаагчийн дүгнэлт зэргийг байршуулсан болно.	64-83
4	Төсвийн орлого, түүний зарцуулалт, гадаадын зээл, тусламж, түүний хуваарилалтыг олон нийтэд тухай бүр мэдээлэх /цахим хуудсаараа/	4.1. Тухайн жилийн төсөв /1 дүгээр сарын 10-ны дотор/	Тус Хорооны цахим хуудасны “шилэн данс”/ “Сонгуулийн Ерөнхий Хороо”/ “төсөв гүйцэтгэл”/ “төсөв ба гүйцэтгэл” цэсэнд Сонгуулийн Ерөнхий Хорооны 2015 оны төсвийг холбогдох хуульд заасан хугацаанд байршуулсан болно.	84
		4.2. Өмнөх оны төсвийн гүйцэтгэл /4 дүгээр сарын 1-ний дотор/	Тус Хорооны цахим хуудасны “шилэн данс”/ “Сонгуулийн Ерөнхий Хороо”/ “төсөв гүйцэтгэл”/ “төсөв ба гүйцэтгэл” цэсэнд Сонгуулийн Ерөнхий Хорооны 2014 оны төсвийн гүйцэтгэл, түүний харьцуулалтын хамт холбогдох хуульд заасан хугацаанд байршуулсан болно.	85-86
		4.3. Сарын төсвийн гүйцэтгэл /дараа сарын 8-ны дотор/	Тус Хорооны цахим хуудасны “шилэн данс”/ “Сонгуулийн Ерөнхий Хороо”/ “төсөв гүйцэтгэл”/ “төсөв ба гүйцэтгэл” цэсэнд Сонгуулийн Ерөнхий Хорооны 2015 оны 1-ээс 9 дүгээр саруудын төсвийн гүйцэтгэл, түүний харьцуулалтын хамт холбогдох хуульд заасан хугацаанд байршуулсан болно.	87-88
		4.4. Улирлын төсвийн гүйцэтгэл /дараа сарын 8-ны дотор/	Тус Хорооны цахим хуудасны “шилэн данс”/ “Ажлын алба”/ “төсөв гүйцэтгэл”/ “төсөв ба гүйцэтгэл” цэсэнд Сонгуулийн Ерөнхий Хорооны 2015 оны 1-ээс 3 дугаар улирлуудын тайлан, төсвийн гүйцэтгэлийг холбогдох хуульд заасан хугацаанд байршуулсан болно.	89
		4.5. Хагас жилийн төсвийн гүйцэтгэл /8 дугаар сарын 15-ны дотор/	Тус Хорооны цахим хуудасны “шилэн данс”/ “Сонгуулийн Ерөнхий Хороо”/ “төсөв гүйцэтгэл”/ “төсөв ба гүйцэтгэл” цэсэнд Сонгуулийн Ерөнхий Хорооны 2015 оны хагас жилийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг холбогдох хуульд заасан хугацаанд байршуулсан болно.	90
		4.6. Хагас жилийн санхүүгийн тайлан /8 дугаар сарын 15-ны дотор/		
		4.7. Дараа жилийн төсвийн төсөл /9 дүгээр сарын 15-ны дотор/	Тус Хорооны цахим хуудасны “шилэн данс”/ “Сонгуулийн Ерөнхий Хороо”/ “төсөв гүйцэтгэл”/ “төсөв ба гүйцэтгэл” цэсэнд Сонгуулийн Ерөнхий Хорооны 2016 оны төсвийн төслийг холбогдох хуульд заасан хугацаанд байршуулсан болно.	91
		4.8. Жилийн эцсийн санхүүгийн тайлан /4 дүгээр сарын 25-ны дотор/	Тус Хорооны цахим хуудасны “шилэн данс”/ “Сонгуулийн Ерөнхий Хороо”/ “төсөв гүйцэтгэл”/ “төсөв ба гүйцэтгэл” цэсэнд Сонгуулийн Ерөнхий Хорооны 2014 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланг холбогдох хуульд заасан хугацаанд байршуулсан болно.	92

4	Төсвийн орлого, түүний зарцуулалт, гадаадын зээл, тус-ламж, түүний хуваарилалтыг олон нийтэд тухай бүр мэдээлэх /цахим хуудсаараа/	4.9.Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт /4 дүгээр сарын 25-ны дотор/	Тус Хорооны цахим хуудасны “шилэн данс”/ “Сонгуулийн Ерөнхий Хороо”/ “төсөв гүйцэтгэл”/ “төсөв ба гүйцэтгэл” цэсэнд Сонгуулийн Ерөнхий Хорооны 2014 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг холбогдох хуульд заасан хугацаанд байршуулсан болно.	93-95
		4.10.Аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ /7 дугаар сарын 1-ний дотор/	Сонгуулийн Ерөнхий Хорооны 2014 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын гэрчилгээгээр “Зөрчилгүй санал дүгнэлт” гарсан болно.	
		4.11. Төсвийн хэмнэлт, хэлтрэлт, түүний шалтгааны тайлбар /улирал бүр/	Тус Хорооны цахим хуудасны “шилэн данс”/ “Сонгуулийн Ерөнхий Хороо”/ “төсөв гүйцэтгэл”/ “төсөв ба гүйцэтгэл” цэсэнд Сонгуулийн Ерөнхий Хорооны 2015 оны төсвийн хэмнэлтийн талаарх төсвийн гүйцэтгэлийн улирлын тайлангуудыг байршуулсан болно.	96-99
		4.12.Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт /өөрчлөлт орсноос хойш ажлын 7 хоногийн дотор/	Тус Хорооны цахим хуудасны “шилэн данс”/ “Сонгуулийн Ерөнхий Хороо”/ “төсөв гүйцэтгэл”/ “төсөв ба гүйцэтгэл” цэсэнд Сонгуулийн Ерөнхий Хорооны 2015 оны төсвийн тодотголыг холбогдох хуульд заасан хугацаанд байршуулсан болно.	100
		4.13.Төсвийн орлого бүрдүүлэлтийг нээлттэй болгох /татварын орлого, татварын бус орлогын талаарх мэдээлэл/	Сонгуулийн Ерөнхий Хороо нь төсвийн орлого бүрдүүлэх чиг үүрэггүй байгууллага бөгөөд аливаа төлбөр хураамж, үйлчилгээний хөлсөөр өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрдүүлдэггүй болно.	-
		4.14.Хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт /өөрчлөлт орсноос хойш 7 хоногийн дотор/		
		4.15. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн хамт /гүйлгээ хийснээс хойш 7 хоногийн дотор/	Тус Хорооны цахим хуудасны “шилэн данс”/ “Ажлын алба”/ “төсөв гүйцэтгэл”/ “таван сая төгрөгөөс дээш орлого, зарлагын мөнгөн гүйлгээ” цэсэнд Сонгуулийн Ерөнхий Хорооны 2015 оны 1-10 дугаар сарын Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээний талаарх мэдээллүүдийг байршуулсан болно.	101
		4.16. Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт /өөрчлөлт орсноос хойш 7 хоногийн дотор/	Сонгуулийн Ерөнхий Хорооны 2013 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 02 дугаар тогтоолоор тус Хорооны Ажлын албаны бүтэц, орон тоог шинэчлэн баталсан бөгөөд түүнд өөрчлөлт ороогүй болно. Батлагдсан бүтэц, орон тооны талаарх холбогдох мэдээллийг тус Хорооны цахим хуудасны “Мэдээллийн ил тод байдал”/ “Хүний нөөц”/ “Албан хаагчдын мэдээлэл” цэсэнд байршуулсан болно.	102-105
		4.17. бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр байхгүй болно.	Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр байхгүй болно.	-

		хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр.		
		4.18.Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийн жагсаалт /тухайн этгээдийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэрийн хамт/-ыг цахим хуудсандаа байршуулах	Сонгуулийн Ерөнхий Хороонд 2015 оны байдлаар Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийн байхгүй тул тус Хорооны цахим хуудасны “шилэн данс”/ “Ажлын алба”/ “байгууллага”/ “Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээд” цэсэнд мэдээлэл агуулаагүй байна.	106
		4.20.Гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр, түүний хэрэгжилтийн талаарх мэдээлэл	Тус Хороонд гадаадын зээл, тусламжаар аливаа төсөл, хөтөлбөр хэрэгжээгүй болно.	-
5	Чиг үүргийн дагуу олгож буй зөвшөөрөл, бүртгэлийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах, олон нийтэд танилцах боломжоор хангах	5.1.Тухайн байгууллагаас олгож буй зөвшөөрөл /тусгай зөвшөөрөл, лиценз, эрх олгох г.м бусад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл/-ийн жагсаалтыг цахим хуудсандаа байршуулах 5.2.Дээрх зөвшөөрөл /тусгай зөвшөөрөл, лиценз, эрх олгох г.м бусад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл/-ийг олгоход шаардлагатай баримт бичгийн жагсаалт, уг асуудлыг шийдвэрлэх журмыгцахим хуудсандаа байршуулах 5.3.Тухайн зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, эрхлэх үйл ажиллагааны чиглэл, зөвшөөрөл олгосон болон дуусгавар болох хугацааг цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байршуулах 5.4.Чиг үүргийн дагуу нууцад хамаарахаас бусад бүртгэлийн талаарх мэдээллийг цахим хуудсаараа ил тод болгох.	Сонгуулийн Ерөнхий Хороо нь аливаа тусгай зөвшөөрөл, лиценз гэх мэт эрх олгох эсхүл эрх, үүрэг үүсэх, өөрчлөгдөх, дуусгавар болохтой холбоотой хуульд заасан бүртгэлийн үйл ажиллагааг явуулдаггүй болно.	-
6	Хүний нөөцийн ил тод байдлыг хангах, олон нийтийг түүнтэй танилцах боломжоор хангах	6.1.Сул орон тооны зарыг цахим хуудсандаа байршуулах /тухай бүр шинэчилсэн/ 6.2.Сонгон шалгаруулалт явуулах талаар олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарласан байх	Тус Хорооны Ажлын албаны Мэдээлэл, судалгаа арга зүйн хэлтэст референт /гадаад харилцааны асуудал хариуцсан ажилтан/ 1 сул орон тооны зарыг тус Хорооны “Мэдээллийн ил тод байдал”/ “Хүний нөөц”/ “Сул орон тооны зар” цэсэнд байршуулсан бөгөөд Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 17.4-т тус тус заасны дагуу Хорооны Ажлын албаны 2015 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн 103 тоот албан бичгийг Төрийн албаны зөвлөлд явуулж улмаар холбогдох нөөцийн санд бүртгэлтэй иргэдийн мэдээлэлтэй танилцах ажил явагдаж байна.	107-109

7	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах, түүнтэй танилцах боломжоор хангах	7.1.Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг цахим хуудсандаа байршуулах /1 дүгээр сарын 10-ны дотор/	Тус Хорооны цахим хуудасны “шилэн данс”/ “Сонгуулийн Ерөнхий Хороо”/ “тендер болон худалдан авалт”/ “худалдан авалтын ерөнхий төлөвлөгөө” цэсэнд Сонгуулийн Ерөнхий Хорооны 2015 оны бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ерөнхий төлөвлөгөөг байршуулсан болно.	110-112
		7.2.Тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам /тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт/, тендерийн урилгыг цахим хуудсандаа байршуулсан байх	Монгол Улсын 2015 оны төсвийн тухай хууль болон төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулиар Сонгуулийн Ерөнхий Хороонд хөрөнгө оруулалтын зардал батлагдаагүй тул тендер шалгаруулалтыг ажил хийгдээгүй болно.	-
		7.3.Тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгааныг цахим хуудсанд байршуулах	Тус Хорооны цахим хуудасны “шилэн данс”/ “Ажлын алба”/ “тендер болон худалдан авалт”/ “Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалт” цэсэнд Сонгуулийн Ерөнхий Хорооны 2015 оны худалдан авсан бараа ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаягийг цахим хуудсандаа байршуулах.	113
		7.4.Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаягийг цахим хуудсандаа байршуулах.	Тус Хорооны цахим хуудасны “шилэн данс”/ “Ажлын алба”/ “тендер болон худалдан авалт”/ “Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалт” цэсэнд Сонгуулийн Ерөнхий Хорооны 2015 оны худалдан авсан бараа ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг зэрэг мэдээллийг байршуулсан болно.	113
		7.5. Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт, шалгалтын дүнг цахим хуудсандаа байршуулах	Тус Хорооны 2014 оны худалдан авах ажиллагаанд Үндэсний аудитын газар аудит хийсэн боловч тайлан, дүгнэлтийг тус Хороонд ирүүлээгүй байна.	-
		7.6.Тендерийн үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоод, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулсан байх.	Монгол Улсын 2015 оны төсвийн тухай хууль болон төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулиар Сонгуулийн Ерөнхий Хороонд хөрөнгө оруулалтын зардал батлагдаагүй тул тендер шалгаруулалтыг ажил хийгдээгүй болно.	-
8	Албан хаагч бүрийн ажил үүргийн хуваарийг тодорхой болгох	8.1.Төрийн албан хаагч нэг бүрийн ажил үүргийн хуваарь, ажлын байрны тодорхойлолтыг баталж мөрдүүлсэн байх	Сонгуулийн Ерөнхий Хорооны Ажлын албаны даргын 2013 оны 2 дугаар сарын 05-ны өдрийн “Ажилд томилох, цалин шинэчлэн тогтоох тухай” 02 дугаар тушаалаар тус Хорооны Ажлын албаны бүтцийг Захиргаа, санхүүгийн хэлтэс, Хууль, эрх зүйн хэлтэс, Мэдээлэл, судалгаа, арга зүйн хэлтэстэй байхаар зохион байгуулсантай холбогдуулж бүх албан хаагчдын ажил үүргийн хуваарийг хавсралтаар баталсан болно. Мөн ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн баталсан. Одоогоор өөрчлөлт ороогүй болно.	114-171

		8.2.Хариуцсан ажил, үүргийн чиглэлийн талаарх мэдээллийг цахим хуудсаараа нээлттэй болгох	Сонгуулийн Ерөнхий Хорооны Ажлын албаны даргын 2013 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 02 дугаар тушаалын хавсралтаар баталсан албан хаагчдын ажил үүргийн хуваарийг тус Хорооны цахим хуудасны “Мэдээллийн ил тод байдал”/“Хүний нөөц”/“Албан хаагчдын ажил үүргийн хуваарь” хэсэгт байршуулсан. Мөн албан хаагчдын мэдээллийг “Мэдээллийн ил тод байдал”/ “Хүний нөөц”/ “Албан хаагчдийн мэдээлэл” цэсэнд байршуулсан болно.	172-174
9	Авлигатай тэмцэх зорилго бүхий төрийн бус байгууллага, иргэдийн сайн дурын хөдөлгөөнийг дэмжих, үйл ажиллагаандаа татан оролцуулах	9.1.Тодорхой төрлийн үйл ажиллагааны хэрэгжилт, явц байдалд хяналт тавих, судалгаа, дүн шинжилгээ хийх ажлыг иргэний нийгмийн байгууллагаар гүйцэтгүүлсэн байх /1 ба түүнээс дээш/ 9.2.Төрийн бус байгууллага, иргэдтэй хамтран хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүнгийн талаарх мэдээллийг тайландаа тусгасан байх 9.3.Хэрэгжүүлсэн ажил, хамтын ажиллагааны талаар хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим хуудсаараа мэдээлсэн байх.	Сонгуулийн Ерөнхий Хороо нь Сонгуулийн төв байгууллагын тухай хуульд заасны дагуу Монгол Улсын Их Хурлын болон Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль, ард нийтийн санал асуулгыг зохион байгуулж явуулах бүрэн эрхтэй байгууллага юм. Үйл ажиллагааны дээрх онцлогоос хамаарч Монгол Улсын Их Хурлын болон Монгол Улсын Ерөнхийлөгчийн ээлжит, нөхөн зэрэг сонгуулиудыг зохион байгуулахдаа сонгуулийн үйл явц, сонгуулийн хууль тогтоомжийн хэрэгжилт зэрэг сонгуулийн бүхий л үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ, мониторингийг гадаад болон дотоодын иргэний нийгмийн байгууллагуудаар хийлгүүлдэг. Тус Хорооны 2013 оны 23 дугаар тогтоолоор “Төрийн бус байгууллага Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн үйл ажиллагаанд хяналт шинжилгээ /мониторинг/ хийх, сонгогчдод аргачилсан туслалцаа үзүүлэх журам”-ыг, 2012 оны 30 дугаар тогтоолоор “Төрийн бус байгууллага сонгуулийн үйл ажиллагаанд хяналт шинжилгээ /мониторинг/ хийх, сонгогчдод аргачилсан туслалцаа үзүүлэх тухай журам”-ыг тус тус баталсан болно. 2015 оны хувьд ээлжит сонгуулийн жил биш тул иргэний нийгмийн аливаа байгууллагатай хяналт, шинжилгээ, мониторингийн үйл ажиллагааг хамтран явуулаагүй болно. Энэ нь дээр дурдсанаар тус Хорооны үйл ажиллагааны онцлогтой хамааралтай юм.	175-182
10	Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг хариуцан зохион байгуулах, уг асуудлаар Авлигатай тэмцэх газартай харилцах эрх бүхий албан тушаалтантай байх	10.1.Эрх бүхий албан тушаалтан /ЭБАТ/-ыг томилсон байх, урамшуулал өгдөг эсэх 10.2.ЭБАТ-ын гүйцэтгэх чиг үүргийг ажлын байрны тодорхойлолт болон ажил үүргийн хуваарьт тусгасан байх 10.3.Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан сургалтад хамрагдсан байх	Ажлын албаны даргын 2014 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн 15 дугаар тушаалаар тус Хорооны Ажлын албаны Хууль, эрх зүйн хэлтсийн дарга П.Наранбатыг албан хаагчдын хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийг бүртгэх, хадгалах эрх бүхий албан тушаалтны үүрэгт ажлаас чөлөөлж, Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах референт Д.Бат-Эрдэнийг албан хаагчдын хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийг бүртгэх, хадгалах эрх бүхий албан тушаалтнаар томилж, Ажлын албаны даргын 2015 оны 01 дүгээр тушаалаар ЭБАТ-ушаалтны нэмэгдлийг шинэчлэн тогтоосон. Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах референтийн ажлын байрны тодорхойлолтод холбогдох өөрчлөлтийг тусгасан. АТГазраас зохион байгуулсан сургалт, семинар, хэлэлцүүлэг тухай бүр оролцсон болно.	183-194

11	Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ёс зүйн дүрмийг тогтоон мөрдүүлэх	11.1.Ёс зүйн дүрмийн төсөлд Авлигатай тэмцэх газраас өгсөн саналыг тусгасан байх	Сонгуулийн Ерөнхий Хорооны албан хаагчдын ёс зүйн дүрмийн төслийг боловсруулж тус Хорооны Ажлын албаны даргын 2014 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн 96 дугаар албан бичгээр дүрмийн төсөлд санал авахаар Авлигатай тэмцэх газарт хүргүүлсэн. Улмаар Сонгуулийн Ерөнхий Хорооны даргын 2014 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн 22 дугаар захирамжаар “Сонгуулийн Ерөнхий Хорооны албан хаагчдын ёс зүйн дүрэм”-ийг баталсан болно. Одоогоор уг дүрэмд нэмэлт, өөрчлөлт ороогүй байна.	195-205
		11.2.Ёс зүйн дүрмийг батлах, мөрдүүлэх /албан хаагчдад танилцуулсан байдал/	2015 онд тус Хорооны албан хаагчдад “Сонгуулийн Ерөнхий Хорооны албан хаагчдын ёс зүйн дүрэм”-ийг дахин танилцуулж, мэдээлэл өгсөн бөгөөд цахим хуудасны “Ил тод байдал”/ “Хүний нөөц”/ “Ёс зүйн дүрэм” цэсэнд байршуулсан.	
		11.3.Зөрчлийн талаарх мэдээлэл хүлээн авах нөхцөл /тогтмол утас ажиллуулах, цахим хуудсанд байршуулах, шуудангаар, биечлэн, хайрцаг байршуулах г.м/-ийг бүрдүүлсэн байх	Тус Хорооны цахим хуудсанд “өргөдөл, гомдол, санал, хүсэлт” нэртэй тусгай баннер байршуулан иргэд, сонгогчдоос санал хүсэлт, өргөдөл, гомдол, зөрчлийн талаарх мэдээллийг тогтмол хүлээн авах нөхцөлийг бүрдүүлэн ажиллаж байна. Мөн өргөдөл гомдол хүлээн авах, хариуцсан ажилтантай холбогдох утас, иргэдийг биечлэн хүлээн авч уулзах хуваарийг цахим хуудаст байршуулсан. Мөн мэдээллийн самбарын дэргэд санал, хүсэлтийн хайрцаг байршуулан ажиллуулж байна.	206-210
		11.4.Зөрчил үүссэн буюу үүсч болзошгүй тохиолдолд урьдчилан сэргийлэх арга хэмжээ /Зөвлөмж/-г авах	Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ашиг сонирхлын зөрчлийн талаарх ойлголтыг өгөх зорилгоор “Таны мэдэх ёстой ашиг сонирхлын зөрчил” нэртэй 2 зөвлөмжийг боловсруулан, гарын авлага болгон хэвлүүлж албан хаагчдад танилцуулж, тараав.	211-213
		11.5.Зөрчил илэрсэн тохиолдолд хуульд заасан хариуцлагыг хүлээлгэсэн байх	Тус Хороонд ашиг сонирхлын зөрчлийн талаарх мэдээлэл, гомдол гараагүй байна.	-
		11.6.Ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг хамт олонд мэдээлсэн байх	Тус Хорооны ажлын албаны 2014 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн хуралдаанаар албан хаагчдад Ажлын албаны даргын 2014 оны 22 дугаар захирамжаар батлагдсан “Сонгуулийн Ерөнхий Хорооны албан хаагчдын ёс зүйн дүрэм”-ийн талаар мэдээлэл өгч, түүний хэрэгжилт болон цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх мэдээллийг хийв.	214-220
12	Давхар ажил эрхлэх боломжтой эсэхийг шийдвэрлэх	12.1.Хууль болон Засгийн газраас зөвшөөрсөн давхар эрхэлж болох ажлын жагсаалтыг гаргаж, албан хаагчдад танилцуулсан байх	Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 18 дугаар зүйлд заасан давхар ажил эрхлэлттэй холбогдсон хязгаарлалт болон хуулийн 18.5 дахь хэсэгт заасан давхар эрхэлж болох ажлын жагсаалтыг Ажлын албаны ажилтнуудад танилцуулсан болно.	221-223
		12.2.Давхар ажил эрхлэлтийн талаарх судалгаатай байх, давхар ажил эрхлэх	Тус Хорооны нийт албан хаагчид Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 18 дугаар зүйлд заасан давхар	224-225

		тохиолдолд зөвшөөрөл олгодог байх	ажил эрхлэх хязгаарлалтын хүрээнд ажил үүргээ гүйцэтгэж байна. Хуулиар зөвшөөрсөн давхар ажил эрхлэлтийн талаарх мэдээллийг тус Хорооны нийт албан хаагчдад танилцуулж, мэдээлэл хийсэн болно. Тус Хорооны цахим хуудасны “Мэдээллийн ил тод байдал”/ “Хүний нөөц”/ “Давхар ажил эрхлэлт” цэсэнд давхар ажил эрхлэлтийн талаарх судалгаа, хуулийн хязгаарлалтын талаарх мэдээллийг байршуулсан болно. Мөн Давхар ажил эрхлэлтийн талаарх судалгааг гаргаж АТГазарт өмнө хүргүүлж байсан бөгөөд одоогоор өөрчлөлт ороогүй байна.	
13	Байгууллагын удирдлагаас гаргаж буй шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангах	13.1.Удирдлагын шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангах нөхцөл, боломжийг бүрдүүлсэн байх /цахим хуудсаар/	Хорооны цахим хуудасны “Хууль тогтоомж”/“Сонгуулийн Ерөнхий Хорооны шийдвэр” цэсэнд Сонгуулийн Ерөнхий Хорооны шийдвэрүүдийг байршуулсан бөгөөд ойлгомжтой, үзэхэд хялбар байлгах үүднээс Монгол Улсын Ерөнхийлөгчийн болон Улсын Их Хурлын сонгууль, аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгууль тус бүрээр баталсан дүрэм, журам, заавар, загвар, маягт зэргээр ангилан байршуулсан болно. 2015 оны 10 дугаар сарын байдлаар тус Хорооноос тогтоол гараагүй байна.	II Боть 1
		13.2.Удирдлагаас гаргасан төрийн болон байгууллагын нууцад хамааруулснаас бусад шийдвэр /тушаал, захирамж/-ийг цахим хуудсандаа байршуулах		
		13.3.Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж /хуульчилсан акт/, дүрэм, журам, зааврыг цахим хуудсандаа байршуулах		
		13.4.Үйлчлүүлэгчээс авч буй төлбөр, хураамжийг цахим хуудсандаа байршуулах		
			Сонгуулийн Ерөнхий Хороо нь иргэд, байгууллагаас аливаа төлбөр, хураамж авдаггүй болно.	-
14	Иргэдийн өргөдөл /санал, мэдэгдэл/, гомдол, хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх шат дамжлагыг цөөрүүлэх, зөрчлийн талаарх мэдээллийг хүлээн авч шалгах	14.1.Хууль тогтоомжоор тогтоосон өөрийн эрхлэх асуудлын хүрээг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлж, сурталчилсан байх.	Монгол Улсад анхны ардчилсан сонгууль зохион байгуулагдсаны 25 жилийн ойг тохиолдуулан тус Хороо нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн тамгын газартай хамтран өөрийн байгууллагын үйл ажиллагаа, анх хэрхэн байгуулагдаж одоог хүртэл хэрхэн ажиллаж байгаа мөн Монгол Улсын сонгуулийн үйл явц, түүнийг зохион байгуулахад гарсан эрх зүйн болоод бусад өөрчлөлт шинэчлэлийн талаар гадаад, дотоодын олон хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэл, нэвтрүүлэг, нийтлэл, ярилцлага хэлбэрээр олон нийтэд мэдээлсэн.	II Боть 2-11
		14.2.Өргөдөл /санал, мэдэгдэл/, гомдол, хүсэлт, мэдээлэл хүлээн авах нөхцөлийг бүрдүүлсэн байх (утас, хайрцаг, санал хүсэлтийн дэвтэр, факс, цахим, бичгээр, амаар г.м хэлбэрээр)	Тус Хорооны цахим хуудсанд “Өргөдөл, гомдол, санал хүсэлт” гэсэн иргэдээс санал хүсэлт, өргөдөл, гомдлыг онлайнар хүлээн авах, хариу өгөх боломж бүхий цэс /Баннер/ үүсгэн ажиллуулж байна. Мөн өргөдөл гомдол хариуцсан ажилтны нэр, холбогдох утас, иргэд хүлээн авах хуваарь зэрэг мэдээллийг Хорооны цахим хуудаст байршуулсан, Санал хүсэлт хүлээж авах тусгай хайрцгийг мэдээллийн самбарын дэргэд байршуулан ажиллуулж байна.	II Боть 12-19

		14.3.Үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн нэр, албан тушаал, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байршуулах.	Тус Хорооны мэдээллийн самбарт болон цахим хуудасны “Өргөдөл, гомдол, санал хүсэлт” хэсэгт өргөдөл, гомдол хариуцсан ажилтны нэр, албан тушаал, утас болон иргэдийг хүлээн авч уулзах хуваарь зэрэг мэдээллийг байршуулсан болно. Мөн Хорооны Ажлын албаны даргын 2013 оны 09 дүгээр тушаалаар тус Хороонд иргэдээс гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай журмыг баталж, мөрдөн ажиллаж байна, мөн уг журмыг цахим хуудасны “Өргөдөл, гомдол, санал хүсэлт” хэсэгт байршуулсан болно.	II Боть 12-19
		14.4.Иргэдийн өргөдөл /санал, мэдэгдэл/, гомдол, хүсэлт, мэдээллийг шийдвэрлэсэн талаар хэвлэл, мэдээллийн хэрэгслээр тогтмол хугацаанд мэдээлсэн байх.	Иргэд, байгууллагаас Сонгуулийн Ерөнхий Хороонд амаар болон бичгээр, цахим хуудсаар дамжуулан гаргасан өргөдөл, гомдол, хүсэлтийг шийдвэрлэсэн талаарх мэдээллийг цахим хуудаснаас эрж, хайхад хялбар байлгах үүднээс тус Хорооны цахим хуудсанд “Өргөдөл гомдлын шийвэрлэлтийн мэдээлэл” тусгай цонх нээн түүгээр мэдээллэж байна.	II Боть 20
15	Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах	15.1.Авлигад өртөх эрсдэлтэй ажил, албан тушаал, үйлчилгээний жагсаалтыг гаргах, уг жагсаалтыг гаргахдаа тодорхой судалгаа, шинжилгээнд тулгуурласан байх 15.2.Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх /хүнд суртал, чирэгдлийг багасгах, сөрөг үзэгдлийг хаах, ашиг сонирхлын зөрчлийн мэдүүлгийг хянах, мэдэгдэл гаргах, албан хаагчийн ажлын байрыг сэлгүүлэх зэрэг үр дүнтэй арга хэмжээг хэрхэн зохион байгуулсан г.м/	Авлигатай тэмцэх газрын Судалгаа шинжилгээний албанаас гаргасан “Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн судалгааны тайлан”, “Авлигын индексийн 2014 оны судалгааны үр дүнгийн тайлан” зэрэг судалгаа, шинжилгээний материал болон тус Хорооны албан хаагчдын дунд явуулсан “Эрсдэлтэй ажил, албан тушаалыг тодорхойлох хуудас” судалгааны асуумжид тулгуурлан авлигад өртөх эрсдэлтэй ажил, албан тушаал, үйлчилгээний жагсаалтыг гаргасан бөгөөд түүнд үндэслэн цаашид авч хэрэгжүүлэх, анхаарах асуудлын талаарх дүгнэлтийг тус Хорооны удирдлагад мэдээлсэн болно. Мөн АТГазрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэст хүсэлт гарган тус Хорооны ажилтан албан хаагчдад “Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг бөглөх” тухай сургалтыг зохион байгуулав.	II Боть 21-45
16	Авлигатай тэмцэх газраас бүрэн эрхийнхээ дагуу гаргасан шийдвэрийг биелүүлэх	16.1.Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн Зөвлөмжийн биелэлт, зохион байгуулсан арга хэмжээ	Авлигатай тэмцэх газраас тус Хорооны авлигын эсрэг үйл ажиллагаатай холбоотойгоор зөвлөмж ирүүлээгүй болно.	-
		16.2.АТГ-ын мөрдөн байцаагчаас гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгуулахаар хүргүүлсэн мэдэгдлийн биелэлт, зохион байгуулсан арга хэмжээ	Авлигатай тэмцэх газрын мөрдөн байцаагчаас гэмт хэргийн шалтгаан нөхцлийг арилгуулах тухай мэдэгдэл тус Хороонд ирүүлээгүй болно.	-
		16.3.АТГ-аас зөрчил арилгуулахаар хүргүүлсэн албан бичгийн биелэлт, зохион байгуулсан арга хэмжээ	Мөн Авлигатай тэмцэх газраас зөрчил арилгуулах, хариуцлага тооцож, арга хэмжээ авахуулахаа хүргүүлсэн албан бичиг байхгүй болно	-
		16.4.АТГ-аас хариуцлага тооцож, арга хэмжээ авахуулахаар хүргүүлсэн албан бичгийн биелэлт		

	16.5.Авлига гарах нөхцөл боломжийг бүрдүүлсэн гэж үзсэн дүрэм, журам, заавар, шийдвэрийг өөрчлөх буюу хүчингүй болгосон эсэх	АТГазраас авлига гарах нөхцөл боломжийг бүрдүүлсэн гэж үзсэн дүрэм, журам, заавар, шийдвэр байхгүй болно.	-
	16.6.АТГ-ын даргын 2012 оны 74 дүгээр тушаалаар батлагдсан “Албан тушаалтан өөрт ногдуулсан сахилгын шийтгэлийн талаарх мэдээллийг холбогдох этгээд болон нийтэд өөрийн зардлаар хүргэх арга хэмжээний журам”-ыг хэрэгжүүлэх чиглэлээр авсан арга хэмжээ	2015 онд тус Хорооны албан хаагчдад сахилгын шийтгэл ногдуулсан зүйлгүй болно.	-

Авлигатай тэмцэх санал, санаачилга

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Төлөвлөгөөний хэрэгжилт	Хуудасны дугаар
17	Авлигын эсрэг соён гэгээрүүлэх, авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг боловсруулж хэрэгжүүлэх	17.1.Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө баталж, хэрэгжүүлсэн байх	Сонгуулийн Ерөнхий Хорооны даргын 2015 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн 02 дугаар захирамжаар тус Хорооны 2015 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг баталсан.	II Боть 46-51 I Боть 8-39
		17.2.Төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээ цаг, хугацаандаа хэрэгжсэн байх	Тус Хорооны авлигын эсрэг үйл ажиллагааны 2015 оны төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ төлөвлөгдсөн хугацаандаа тухай бүр хэрэгжиж байгаа бөгөөд, төлөвлөгөөний хэрэгжилтийг хагас жилээр тооцож гаргаж цахим хуудасны “Сонгуулийн Ерөнхий Хорооны авлигын эсрэг үйл ажиллагаа” цонхонд байршуулсан болно.	II Боть 52-56 I Боть 8-39
		17.3.Хэрэгжилтийн тайланг тогтсон хугацаа /жил бүрийн 11 сарын 15-ны дотор/-нд АТГ-т хүргүүлсэн байх	Төлөвлөгөөний хэрэгжилтийн тухай тайланг тус Хорооны 2015 оны 11 дүгээр сарын ...-ны өдрийн ... тоот албан бичгээр Авлигатай тэмцэх газарт хүргүүлсэн болно.	-

	<p>Авлигын эсрэг соён гэгээрүүлэх, авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг боловсруулж хэрэгжүүлэх</p>	<p>17.4.Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд гарч буй хүндрэл бэрхшээл, ололт амжилт, хүрсэн үр дүн, цаашид хэрэгжүүлэх ажлын саналыг тайланд тусгасан байх</p>	<p>Хэдийгээр төрийн байгууллагын авлигын эсрэг явуулж буй үйл ажиллагааг үнэлэх аргачлалыг шинэчлэн баталж, байгууллагуудын үйл ажиллагааны ерөнхий чиглэлээр ангилж, үнэлэх шалгуур үзүүлэлтийг шинэчилсэн боловч тус Хорооны хувьд үйл ажиллагааны үндсэн чиглэл, онцлогоос хамаарч ээлжит сонгууль явагдаагүй жилд төрийн бус байгууллагыг үйл ажиллагаандаа татан оролцуулах, хамтран ажиллах чиглэл хязгаарлагдмал байдгыг үнэлгээ хийж буй шинжээчид анхаарах шаадлагатай юм. Гэсэн хэдий ч тус Хорооны удирдлагаас байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагаанд тусгагдсан арга хэмжээ, түүнийг үнэлэх шалгуур үзүүлэлтийг хангах, авлигаас урьдчилан сэргийлэх, байгууллагын албан хаагчдыг авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байлгах, мэдээллээр хангах, төрийн бус байгууллагатай аливаа хэлбэрээр хамтран ажиллах, мэдээллийн ил тод нээлттэй байлгах чиглэлээр бүхий л боломжит хэлбэрээр анхаарч ажиллаж байгааг дурдах нь зүйтэй. Мөн Авлигын эсрэг үйл ажиллагааг үнэлэх шалгуур үзүүлэлтийг шинэчилж шалгуур үзүүлэлтүүдийг илүү оновчтой, тодорхой болгосон нь төрийн байгууллагын хувьд авлигын эсрэг явуулж буй бүхий л үйл ажиллагаагаа иргэдэд хүртээмжтэй, мэдээллээр хангахуйц байдлаар зохион байгуулахад чухал нөлөө үзүүлж байгаа нь түүний ач холбогдлыг улам нэмэгдүүлсэн гэж үзэж байна. Цаашид Сонгуулийн Ерөнхий Хороо нь авлигын эсрэг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх, байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангахад чиглэгдсэн арга хэмжээг үйл ажиллагааныхаа төлөвлөгөөнд тусгаж, иргэд олон нийтэд мэдээлэхийг хуулиар хүлээн зөвшөөрсөн бүхий л мэдээ, мэдээлэл, үйл ажиллагааны тайланг цаг тухай бүрт нь хүртээмжтэй, ойлгомжтой арга хэлбэрээр хүргэж ажиллах, байгууллагын албан хаагчдыг авлига ашиг сонирхлын зөрчлөөс ангид байлгах, мэдээллээр хангах чиглэлээр илүү анхаарч ажиллахаар төлөвлөж байна.</p>	-
18	<p>Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзлэл, хүчин чармайлт</p>	<p>18.1.Авлигын эсрэг төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагаас гаргасан санал, санаачилга /уриа, уриалга, мэдэгдэл, амлалт г.м/-д нэгдсэн байдал</p>	<p>Авлигын нөхцөл байдал, цар хүрээ, шалтгаан, хэлбэрийг бодитой, үнэн зөвөөр тогтоох зорилгоор АТГазраас зохион байгуулдаг судалгаануудын нэг болох “Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх шинжээчдийн төсөөллийн 2014 оны судалгааны тайлан, түүний талаар АТГазраас 2015 онд мэдээлэл өгч, хэлэлцүүлэг, сургалт зохион байгуулсан. Уг төсөөллийн судалгаанд тулгуурласан санал, зөвлөмжид Монгол Улсад өндөр</p>	

	<p>Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзлэл, хүчин чармайлт</p>	<p>18.2.Удирдах албан тушаалтнуудын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзлэл, хүчин чармайлт, санаачилга, тэдний үлгэр жишээ байдал</p>	<p>түвшний авлигад нөлөөлж буй хүчин зүйлд улс төрийн намын санхүүжилтийн тогтолцоо, сонгуулийн санхүүжилт, түүний эрх зүйн зохицуулалт нөлөөлж буйг дурдаад улс төрийн намын санхүүжилтийн тогтолцоо, сонгуулийн санхүүжилт түүний эрх зүйн тогтолцоог өөрчлөх шаардлагатайг дурдсан байна. Энэхүү судалгааны тайлан, түүний дүгнэлт болон зөвлөмжид өндөр түвшний авлигыг бууруулах арга замыг тодорхойлсон байдал болон “Нээлттэй нийгэм форум”, “Глоб интернэйшнл” зэрэг төрийн бус байгууллагуудаас санаачлан зохион байгуулсан улс төрийн намын санхүүжилт, сонгуулийн санхүүжилтийн асуудлаарх хэлэлцүүлгүүдэд оролцож, улмаар Сонгуулийн Ерөнхий Хорооноос сонгуулийн хууль, улс төрийн намын тухай хууль, сонгуулийн санхүүжилтийн тогтолцоо зэрэг асуудлаар санал боловсруулан холбогдох ажлын хэсгүүдэд хүргүүлэх ажлыг зохион байгуулан ажиллаа. Тухайлбал: Дээр дурдсан чиглэлээр судалгаа, үйл ажиллагаа явуулдаг иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл болсон “Глоб интернейшнл” ТББ, “Сонгогчдын боловсрол төв” ТББ, “Нээлттэй нийгэм форум”-уудад тус Хорооны ажлын албаны даргын 2015 оны 45 дугаар “хамтран ажиллах” тухай албан бичиг хүргүүлж сонгуулийн зардал, санхүүжилтийг ил тод, нээлттэй болгох асуудлаар санал ирүүлж хамтран ажиллахыг хүссэн. Түүний үр дүнд Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо Авлигатай тэмцэх газар, “Сонгогчдын боловсрол” төвтэй хамтран “Сонгуулийн санхүүжилт-шинэчлэлийн асуудал” сэдэвт хэлэлцүүлгийг Төрийн ордонд зохион байгуулав. Энэхүү хэлэлцүүлэгт тус Хорооны Ажлын албаны дарга оролцож сонгуулийн санхүүжилтийн эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох чиглэлээр санал, зөвлөмжийг өгч оролцов. Мөн Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын Авлигын эсрэг үнэлгээний тайлангийн төсөлтэй танилцаж, тус Хорооны Ажлын албаны 2015 оны 95 тоот албан бичгээр санал хүргүүлж ажиллаа. АТГазрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэст хүсэлт гарган тус Хорооны ажилтан албан хаагчдад “Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг бөглөх” тухай сургалтыг зохион байгуулав. Мөн Авлигын мөн чанар, шалтгаан, хор хөнөөл сэдэвт мэдээллийг тус Хорооны албан хаагчдад танилцуулах ажлыг зохион байгуулав.</p>	<p>57-83</p>
		<p>18.3.Авлигын эсрэг арга хэмжээнд зориулан тусгайлан хөрөнгө гаргасан</p>	<p>Авлигатай тэмцэх газраас тус Хороонд явуулсан сургалтын агуулга, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс тус Хорооны нийт ажилтан албан хаагчдыг урьдчилан сэргийлэх, холбогдох мэдээллээр хангах чиглэлээр удирдлагын зүгээс анхаарч “Авлига, ашиг сонирхлын зөрчил, ба ил тод байдал”-ын талаар холбогдох зөвлөмж бүхий</p>	<p>84-86</p>

		эсэх /зарцуулалт/	гарын авлагыг тодорхой зардал гарган хэвлүүлж, албан хаагчдад танилцуулах, тараах арга хэмжээг авч ажиллаа. Мөн байгууллагын ЭБАТушаалтны ажиллах журам, мэдүүлэг гаргагчийн ХАСХОМ болон бусад баримт материалыг хадгалах зориулалт бүхий сэйфний асуудлыг шийдвэрлэж албан тушаалтны ХАСХОМ-ыг бүртгэх, хянах, хадгалах тухай журамд заасны дагуу үйл ажиллагаа явуулах нөхцлийг бүрдүүлэв.	
19	Албан хаагчдын шударга байдал ба түүнийг нэмэгдүүлэх	19.1.Албан тушаалтан, албан хаагчдын шударга байдлыг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээ /шударга ёс, ёс зүй, сонирхлын зөрчлийн талаарх сургалт, хэлэлцүүлэг, ярилцлага, өдөрлөг, зөвлөмж өгөх г.м/-г авах	АТГазрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэст хүсэлт гарган тус Хорооны ажилтан албан хаагчдад “Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг бөглөх” тухай сургалтыг зохион байгуулав. Авлигатай тэмцэх газраас тус Хороонд явуулсан сургалтын агуулга, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс тус Хорооны нийт ажилтан албан хаагчдыг урьдчилан сэргийлэх, холбогдох мэдээллээр хангах чиглэлээр удирдлагын зүгээс анхаарч “Авлига, ашиг сонирхлын зөрчил, ба ил тод байдал”-ын талаар холбогдох зөвлөмж бүхий гарын авлагыг хэвлүүлж, албан хаагчдад танилцуулах, тараах арга хэмжээг авч ажиллаа. Мөн АТГазраас боловсруулсан Авлигын мөн чанар, шалтгаан, хор хөнөөл сэдэвт сургалтын материалаар мэдээлэл бэлтгэж тус Хорооны албан хаагчдад танилцуулах ажлыг зохион байгуулав.	87-91
		19.2.Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг үнэн зөв, шударга болгох чиглэлээр авсан арга хэмжээ	Төрийн албаны зөвлөлийн 2012 оны 134 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх журам”-ын дагуу Ажлын албаны ажилтнуудын үр дүнгийн гэрээг дүгнэж байгаа болно. Уг журмыг Хорооны цахим хуудасны “Ил тод байдал”/“Хүний нөөц”/ “Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх” цэсэнд байршуулсан.	92
		19.3.Байгууллагын дотоод аудит, хяналт шалгалтын хүрээнд илрүүлсэн авлигын зөрчил, авсан арга хэмжээ	Байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгт бэлтгэх зорилгоор тус Хорооны албан хаагчдад явуулсан албан хэрэг хөтлөлт, ажлын зохион байгуулалтын үзлэгээр аливаа зөрчил, авлигын зөрчил илрээгүй болно.	-
		19.4.Бусад байгууллага, иргэдийн гомдлоор илэрсэн зөрчил, авсан арга хэмжээ	Иргэд, байгууллагаас тус Хороонд хандаж аливаа зөрчил гарсан талаар гомдол гараагүй болно.	-
		19.5.Авлигатай тэмцэх газрын шалгалтаар илэрсэн авлигын гэмт хэрэг /шүүхээр шийдвэрлэгдсэн/ ба бусад зөрчил	Тус Хороонд Авлигатай тэмцэх газрын шалтгалтаар илэрсэн авлигын гэмт хэрэг, зөрчил байхгүй болно.	-